



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 10 сарын 15 өдөр

Дугаар А/538

Мөрөн сум

Төрийн захиргааны албан хаагчдад мөнгөн
урамшуулал олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4, 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, Төрийн албаны тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.7, 51 дүгээр зүйлийн 51.3, Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн 83 дугаар тогтоол, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн 04 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Орон нутгийн байгууллагуудын төрийн захиргааны албан тушаалд тасралтгүй ажиллаж байгаа төрийн захиргааны албан хаагчдад таван жил тутамд нэг удаа олгох урамшууллын жагсаалтыг хавсралтаар баталсугай.

2.Мөнгөн урамшуулалд олгох зардлыг төрийн албан хаагчдад олгох мөнгөн тэтгэмж тусламжийн зардлаас шилжүүлэхийг Засаг даргын Тамгын газар (Э.Улам-Өсөх)-д зөвшөөрсүгэй.

3.Холбогдох хууль, тогтоол журмын дагуу холбогдох баримт материалын бүрдлийг бүрэн зөв хангаж ажиллахыг төсөв захирагч нарт даалгасугай.

4.Захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Г.Базар)-д даалгасугай.

ДАРГА



П.ЛХАГВАЖАВ

Аймгийн Засаг даргын 2024 оны
10 дугаар сарын 15 ний өдрийн
1/53 дугаар захирамжийн
хавсралт

Төрийн захиргааны албан хаагчдад олгох мөнгөн
урамшууллын жагсаалт /сум, байгууллагаар/

(мян.төгрөг)

№	Байгууллага	Хүний тоо	Мөнгөн дүн
1	Худалдан авах ажиллагааны газар	1	6,875.0
2	Алаг-Эрдэнэ сумын ЗДТГ	1	6,765.0
3	Түнэл сумын ЗДТГ	1	6,875.0
Нийт дүн		3	20,515.0